МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛАЛ

Судалгааны төрөл: **Мэдээлэл лавлагаа**
Судалгааны код: **СТ-25/413**
Огноо: 2025.09.02

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Х.Ганхуяг

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт

Судалгаа удирдсан: Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр

Судлаач: Р.Нургүл

Улаанбаатар хот
2025

Агуулга

Удиртгал 2
Хүснэгтийн жагсаалт 3
Нэг. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН СТАНДАРТУУД 4
1.1 Төрийн санхүүгийн статистикийн гарын авлага....4
1.2 Төсвийн орлогын ангилал 4
1.3 Төсвийн зарлагын ангилал 6
Хоёр. УЛС ОРНУУДЫН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛАЛ 8
Судалгааны үр дүн 12
Ном зүй....13

Удиртгал

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас ирүүлсэн захиалгын дагуу “Төсвийн орлого, зарлагын ангилал” сэдэвт судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Монгол Улстай эдийн засгийн өсөлтөөрөө ойролцоо улс орнуудын төсвийн орлого, зарлагын ангиллын талаар судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд, Бүгд Найрамдах Киргиз Улс (цаашид Киргиз), Бүгд Найрамдах Армени Улс (цаашид Армени), Бүгд Найрамдах Молдова Улс (цаашид Молдова), Гүрж Улс (цаашид Гүрж) зэрэг дөрвөн улсын туршлагыг судлав.

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны тайлан үндсэн хоёр хэсэгтэй. Үүнд:

1. Олон улсын хэмжээнд төсвийн орлого, зарлагын ангиллыг тодорхойлдог стандарт арагчлалын талаар;
2. Улс орнуудын төсвийн орлого, зарлагын ангилалын талаар тус тус авч үзлээ.

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын байгууллагуудаас эмхлэн нийтэлсэн судалгаа, зөвлөмж, болон бусад мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлд тулгуурлан судалгааны удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: төсөв, төсвийн орлого, зарлагын ангилал.

Key words: budget, classification of budget revenue and expense.

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Төсвийн орлогын ангилал 5
Хүснэгт 2. Төсвийн зарлагын ангилал.....6
Хүснэгт 3. Улс орнуудын төсвийн орлогын ангилал (GFSM 2014 стандартын дагуу) 8
Хүснэгт 4. Улс орнуудын төсвийн зарлагын ангилал (GFSM 2014 стандартын дагуу).....10

Нэг. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ОЛОН УЛСЫН АНГИЛЛЫН СТАНДАРТУУД

Олон улсын хэмжээнд төсвийн орлого, зарлагын ангиллыг тодорхойлохдоо тодорхой стандарт аргачлалуудыг хэрэглэдэг. Тухайлбал, Олон улсын валютын сангийн Төрийн санхүүгийн статистикийн гарын авлага (Government Finance Statistics Manual – GFSM 2014), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Засгийн газрын үйл ажиллагааны ангилал (Classification of the Functions of Government), мөн Олон улсын валютын сан, Европын Холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Дэлхийн Банк зэрэг байгууллагуудын хамтран боловсруулсан Үндэсний тооцооны систем (System of National Accounts 2008) зэрэг стандартууд байдаг.

Эдгээр стандартыг улс орнуудын төсвийн гүйцэтгэлийг харьцуулан дүгнэх, нэгдсэн статистикийн мэдээлэл боловсруулах, макро эдийн засгийн дүн шинжилгээ хийхэд ашиглаж байна. Хамгийн өргөн хэрэглэгддэг нь GFSM 2014 стандарт бөгөөд Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ), Европын Холбооны Статистикийн газар (Евростат) ч мөн адил GFSM-тэй нийцүүлж өгөгдөл цуглуулдаг. Энэ судалгаанд GFSM 2014 стандартын хүрээнд төсвийн орлого, зарлагыг хэрхэн ангилсан талаар авч үзлээ.

1.1 Төрийн санхүүгийн статистикийн гарын авлага

Олон улсын валютын сан (ОУВС)-ийн боловсруулсан Төрийн санхүүгийн статистикийн гарын авлага (GFSM 2014)-ыг улс орнуудын төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өрийн өөрчлөлтийн мэдээллийг нэг стандартын дагуу ангилж санхүүгийн бодлого, эдийн засгийн дүн шинжилгээ хийхэд ашигладаг. GFSM 2014 стандартын ангилал нь дараах үндсэн бүтэцтэй байна (IMF, 2014). Үүнд:

- **Орлого (Revenue):** Төрийн байгууллагын татвар, нийгмийн даатгалын шимтгэл, өмчийн орлого болон бусад эх үүсвэрээс бүрдэх төсвийн орлого;
- **Зарлага (Expense):** Нийгмийн шилжүүлэг, цалин, бараа үйлчилгээний хэрэглээ, татаас, хүүгийн төлбөр зэрэг төсвийн зарлагууд;
- **Цэвэр хөрөнгийн өөрчлөлт (Net acquisition of non-financial assets):** Төрийн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар зэрэг биет бус болон биет хөрөнгийн худалдан авалт, борлуулалтын цэвэр дүн;
- **Санхүүгийн гүйлгээ (Financial transactions):** Засгийн газрын өрийн хэрэгсэл, зээл болон бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт зэргийг харуулна.

Эдгээрээс төсвийн орлого, зарлагын ангиллыг дэлгэрүүлэн авч үзье.

1.2 Төсвийн орлогын ангилал

GFSM 2014 стандартын дагуу төсвийн орлогыг татварын (11), нийгмийн даатгалын шимтгэл (12), тусламж (13) болон бусад орлого (14) гэсэн үндсэн дөрвөн бүлэгт хуваадаг.

Хүснэгт 1.Төсвийн орлогын ангилал

Код	Ангилал	Дэд ангилал
1	ОРЛОГО (REVENUE)	
11	Татвар (Taxes)	
111	Ашиг, орлогын татвар болон хөрөнгийн оруулалтын өгөөж (Taxes on income, profits, and capital gains)	1111 Хувь хүний орлогын татвар 1112 Корпорац болон бусад аж ахуйн нэгжийн татвар 1113 Бусад ашиг, орлогын татвар
112	Цалин болон ажиллах хүчний татвар (Taxes on payroll and workforce)	
113	Өмчийн татвар (Taxes on property)	1131 Үл хөдлөх хөрөнгийн давтагдах татвар 1132 Цэвэр хөрөнгийн давтагдах татвар 1133 Өв залгамжлал, бэлэглэлийн татвар 1135 Хөрөнгийн нэг удаагийн татвар 1136 Бусад өмчийн татвар
114	Бараа, үйлчилгээний татвар (Taxes on goods and services)	1141 Бараа, үйлчилгээний ерөнхий татвар 11411 НӨАТ 11412 борлуулалтын татвар 11413 эргэлтийн болон бусад үндсэн татвар 11414 санхүү, хөрөнгийн гүйлгээний татвар 1142 Онцгой албан татвар 1143 Төрийн онцгой эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас төсөвт төвлөрөх ашиг 1144 Тодорхой үйлчилгээний татвар 1145 Бараа ашиглах болон зөвшөөрлийн татвар 11451 машины татвар 11452 Бусад зөвшөөрлийн татвар 1146 Бусад бараа, үйлчилгээний татвар
115	Олон улсын худалдаа, гүйлгээний татвар (Taxes on international trade and transactions)	1151 Импортын татвар 1152 Экспортын татвар 1153 Гаалийн албан татвар 1154 Гадаад худалдааны татвар 1155 Гүйлгээний татвар 1156 Бусад
116	Бусад татвар (Other taxes)	1161 Зөвхөн бизнесийн үйл ажиллагаанд ногдуулдаг бусад татварууд 1162 Бизнесээс бусад этгээдэд ногдуулдаг, эсвэл тодорхойгүй бусад татварууд
12	Нийгмийн даатгалын орлого (Social contributions)	121 Нийгмийн хамгааллын шимтгэл 1211 ажилтны төлөх шимтгэл

		1212 ажил олгогчийн төлөх шимтгэл 1213 хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажилгүй этгээдийн сайн дураар төлөх шимтгэл 1214 бусад 122 Бусад нийгмийн даатгалын шимтгэл
13	Тусламж (Grants)	131 Гадаад улсын засгийн газраас (Урсгал, хөрөнгийн) 132 Олон улсын байгууллага (урсгал болон хөрөнгийн) 133 Бусад засгийн газрын нэгжээс (урсгал болон хөрөнгийн)
14	Бусад орлого (Other revenue)	141 Өмчийн орлого 1411 хүүгийн орлого 1412 ногдол ашиг 1413 төрийн өмчит болон төрийн оролцоотой байгууллагаас татсан орлого 1414 хөрөнгө оруулалтын орлого 1415 түрээсийн орлого 1416 гадаадын шууд хөрөнгө оруулалтын дахин хөрөнгө оруулсан ашиг 142 Бараа, үйлчилгээний борлуулалт 143 Торгууль, төлбөр, хураамж 144 Бусад шилжүүлэг (урсгал, хөрөнгийн) 145 Даатгал, баталгааны төлбөр, нэхэмжлэл

Эх сурвалж: (IMF, 2014)

1.3 Төсвийн зарлагын ангилал

GFSM 2014 стандартын хүрээнд төсвийн зарлагыг ажилтны цалин, урамшуулал (21), бараа, үйлчилгээний зардал (22), үндсэн хөрөнгийн элэгдэл (23), өрийн хүүгийн төлбөр (24), татаас (25), шилжүүлэг (26), нийгмийн тэтгэмж, халамж (27), бусад зардал (28) зэрэг 8 үндсэн бүлэгт хуваасан байна.

Хүснэгт 2. Төсвийн зарлагын ангилал

Код	Ангилал	Дэд ангилал
2	ЗАРЛАГА (EXPENSE)	
21	Ажилтны цалин, урамшуулал (Compensation of employees)	211 Цалин, урамшуулал 2111 бэлэн мөнгөөр 2112 бараа, үйлчилгээ хэлбэрээр 212 Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2121 бодит шимтгэл 2122 тооцоолсон шимтгэл
22	Бараа, үйлчилгээний хэрэглээ (Use of goods and services)	
23	Үндсэн хөрөнгийн элэгдэл (Consumption of fixed capital)	

24	Өрийн хүүгийн төлбөр (Interest)	241 Гадаадын иргэд, байгууллагад 242 Төрийн байгууллагаас бусад дотоодын нэгжид 243 Төрийн байгууллага хоорондын
25	Татаас (Subsidies)	251 Төрийн өмчит корпорацад олгосон 252 Хувийн хэвшлийн ААН-д олгосон 253 Бусад салбарт олгосон
26	Шилжүүлэг (Grants)	261 Гадаадын засгийн газарт 2611 урсгал 2612 хөрөнгийн 262 Олон улсын байгууллагад 2621 урсгал 2622 хөрөнгийн 263 Бусад төрийн байгууллагад 2631 урсгал 2632 хөрөнгийн
27	Нийгмийн тэтгэмж, халамж (Social benefits)	271 Нийгмийн хамгааллын тэтгэмж 2711 бэлэн мөнгөөр 2712 бараа, үйлчилгээ хэлбэрээр 272 Нийгмийн халамжийн тэтгэмж 2721 бэлэн мөнгөөр 2722 бараа, үйлчилгээ хэлбэрээр 273 Ажил эрхлэлтийн холбогдолтой тэтгэмж 2731 бэлэн мөнгөөр 2732 бараа, үйлчилгээ хэлбэрээр
28	Бусад зардал (Other expense)	281 Хүүгээс бусад өмчийн зардал 2811 ногдол ашиг 2812 төрийн өмчит болон төрийн оролцоотой байгууллагаас татсан ашиг 2813 Хөрөнгө оруулалтын орлогоос бусдад хуваарилах ашиг 2814 Түрээс 2815 Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дахин хөрөнгөжүүлэлт 282 Бусад 2821 урсгал шилжүүлэг 2822 бусад хөрөнгийн шилжүүлэг 283 Даатгал, баталгааны схемтэй холбоотой төлбөрүүд 2831 даатгалын шимтгэл, төлбөр 2832 хөрөнгийн нэхэмжлэл

Эх сурвалж: (IMF, 2014)

Хоёр. УЛС ОРНУУДЫН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛАЛ

Ихэнх улс оронд тухайн улсын хууль эрх зүйн тогтолцоо, дотоодын хэрэгцээ (салбарын төсөв хуваарилах, хяналт тавих)-д илүү тохирсон үндэсний ангиллын системийг хэрэглэдэг, харин олон улсын түвшинд тайлагнахдаа GFSM 2014 эсвэл түүнтэй уялдсан ангилалд хөрвүүлж тайлагнадаг.

Ихэнх улс орнууд, ялангуяа хөгжиж буй болон ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсан орнууд үндэсний төсвийн ангиллаа GFSM-тэй нийцүүлж боловруулсан байдаг бөгөөд орлого, зарлага нь дараах ерөнхий бүтэцтэй байна. Үүнд:

- **Орлогын бүлэг**: татвар, нийгмийн даатгалын шимтгэл, буцалтгүй тусламж, өмчийн орлого, бусад орлого.
- **Зарлагын бүлэг**: цалин, бараа үйлчилгээний хэрэглээ, татаас, нийгмийн шилжүүлэг, хүүгийн төлбөр, хөрөнгө оруулалт гэх мэт.

Олон улсын валютын сангийн тайланд дурдсанаар, улс орнууд үндэсний статистик мэдээллээ ОУВС, Дэлхийн банк, НҮБ зэрэг байгууллагад тайлагнадаг тул үндэсний ангиллын бүтэц нь ихэвчлэн GFSM стандартын дагуу байдаг. Энэ судалгаанд манай улстай эдийн засгийн өсөлт болон хөгжлийн түвшинг харьцуулж болохуйц Киргиз, Армени, Гүрж, Молдова зэрэг орнуудыг авч үзлээ. Тус орнуудын төсвийн ангилал нь GFSM стандарттай шууд уялдсан, зөвхөн кодчилолын форматын хувьд ялгаатай байна.[1]

Хүснэгт 3. Улс орнуудын төсвийн орлогын ангилал (GFSM 2014 стандартын дагуу)

Ангилал	Дэд ангилал
КИРГИЗ (IMF, 2025)	
Татвар (Taxes)	• Ашиг, орлогын татвар болон хөрөнгө оруулалтын өгөөж - хувь хүний орлогын татвар - корпорац болон бусад аж ахуйн нэгжээс авах татвар • Өмчийн татвар - газрын татвар - хөрөнгийн татвар • Бараа, үйлчилгээний татвар - НӨАТ - борлуулалтын татвар - онцгой татвар • Олон улсын худалдаа, гүйлгээний татвар
Нийгмийн даатгалын орлого (Social contributions)	
Тусламж (Grants)	• Хөтөлбөрийн тусламж • Төрийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн буцалтгүй тусламж

[1] Жишээлбэл, зарим улс орон “1.1.1” гэсэн шаталсан кодчлолын формат ашигладаг бол, зарим нь “111” гэх мэт нийлмэл тоон кодчилол хэрэглэдэг.

Бусад орлого (Other revenue)	
АРМЕНИ (IMF, 2024) **орлого+тусламж**	
Орлого	
Татвар (Taxes)	• НӨАТ • Ашиг орлогын, хялбаршуулсан болон урьдчилан тогтоосон орлогын хэмжээнд үндэслэж ногдуулах татвар • Хувь хүний орлогын татвар • Гаалийн татвар • Бусад
Нийгмийн даатгалын орлого (Social contributions)	
Бусад орлого (Other revenue)	
Тусламж (Grants)	
ГҮРЖ (IMF, 2025)	
Татвар (Taxes)	• Ашиг, орлогын татвар болон хөрөнгө оруулалтын өгөөж - хувь хүний орлогын татвар - аж ахуйн нэгжийн татвар • Өмчийн татвар • Бараа, үйлчилгээний татвар - бараа, үйлчилгээний ерөнхий татвар (НӨАТ) - онцгой татвар • Олон улсын худалдаа, гүйлгээний татвар • Бусад татвар
Тусламж (Grants)	
Бусад орлого (Other revenue)	
МОЛДОВА (IMF, 2024) **орлого+тусламж**	
Орлого (Revenue)	
Татвар (Taxes)	• Хувь хүний орлогын татвар • Аж ахуйн нэгжийн татвар • Өмчийн татвар • НӨАТ • Онцгой татвар • Гадаад худалдааны татвар • Бусад татвар • Нийгмийн даатгалын шимтгэл • Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
Татварын бус орлого (Non-tax revenues)	• Молдовагийн Төв банк ашгаасаа улсын төсөвт шилжүүлдэг татварын бус орлого.
Тусламж (Grants)	• Төсвийн дэмжлэг • Төсөл, хөтөлбөрийн буцалтгүй тусламж

Киргиз, Армени, Гүрж, Молдова улсуудын орлогын ангилал нь GFSM-ийн татварын, нийгмийн даатгалын, тусламжийн, бусад орлого гэсэн үндсэн бүтэцтэй ижил боловч зарим ялгаанууд байна. Тухайлбал, Молдовад татварын бус орлого (Төв банкны ашиг) гэсэн ангилалтай, мөн нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тусад нь ангилахгүй татварын орлогод хамруулдаг. Армени, Молдовад тусламжийг орлоготой нэгтгэн тайлагнах, Гүржид нийгмийн даатгалын шимтгэлийг тусад нь ангилдаггүй зэрэг онцлогтой байна.

Хүснэгт 4. Улс орнуудын төсвийн зарлагын ангилал (GFSM 2014 стандартын дагуу)

Ангилал	Дэд ангилал
КИРГИЗ (IMF, 2025)	
Ажилтны цалин, урамшуулал (Compensation of employees)	• Цалин, урамшуулал • Нийгмийн даатгалын шимтгэл
Худалдан авалт\Бараа, үйлчилгээний хэрэглээ (Purchases\Use of goods and services)	
Өрийн хүүгийн төлбөр, хураамж, шимтгэл (Interest payments and fees)	• Гадаад • Дотоод
Төрийн өмчит корпорацын татаас (Subsidies to public corporations)	
Шилжүүлэг (Grants)	• Олон улсын байгууллагад • Засгийн газрын бусад нэгжид
Нийгмийн тэтгэмж, халамж (Social benefits)	
Бусад зардал (Other expense)	• Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудад олгосон хөрөнгийн шилжүүлэг
АРМЕНИ (IMF, 2024)	
Зардал (Expense)	• Цалин хөлс • Хувийн тэтгэврийн хуримтлалын дансанд төрөөс хийсэн төлбөр • Татаас • Өрийн хүүгийн төлбөр • Нийгмийн тэтгэмж болон тэтгэвэр - тэтгэвэр\нийгмийн даатгалаас олгох тэтгэмж - нийгмийн халамжийн тэтгэмж • Бараа, үйлчилгээний хэрэглээ • Шилжүүлэг • Бусад
Санхүүгийн бус хөрөнгийн гүйлгээ (Transactions in nonfinancial assets)	• Санхүүгийн бус хөрөнгийн худалдан авалт • Санхүүгийн бус хөрөнгийн борлуулалт
ГҮРЖ (IMF, 2025)	
Зардал (Expense)	• Ажилтны цалин, урамшуулал

	• Бараа, үйлчилгээний • Өрийн хүүгийн төлбөр - гадаад - дотоод • Хувийн тэтгэврийн хуримтлалын дансанд төрөөс хийсэн төлбөр • Татаас • Шилжүүлэг • Нийгмийн халамжийн тэтгэмж • Бусад
Санхүүгийн бус хөрөнгийн цэвэр худалдан авалт (Net acquisition of nonfinancial assets)	• Өсөлт (капитал зардал, хөрөнгө оруулалт) • Бууралт (хувьчлалын орлого)
МОЛДОВА (IMF, 2024) **зардал+ зээл, эргэн төлөлтийн цэвэр дүн**	
Урсгал зардал (Current expenditure)	• Цалин хөлс • Бараа, үйлчилгээний • Өрийн хүүгийн төлбөр - дотоод - гадаад • Шилжүүлэг - өрхөд чиглэсэн - бизнесийн салбарт чиглэсэн • Бусад
Хөрөнгийн зардал (capital expenditure)	

Зарлагын ангилал нийтлэг бүтэцтэй боловч улс орнуудын онцлогоос хамаарч нэмэлт ангилалтай байна. Жишээлбэл, Армени, Гүржид хувийн тэтгэврийн хуримтлалын дансанд хийх төлбөрийг оруулсан. Молдовад зарлагыг урсгал болон хөрөнгийн зардал гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваасан бол Гүрж, Арменид зардал болон санхүүгийн бус хөрөнгийн гэж хуваасан байна.

Судалгааны үр дүн

Улс орнуудын төсвийн орлого, зарлагын ангилал нь ОУВС, Дэлхийн банк, НҮБ зэрэг олон улсын байгууллагуудад тайлагнах шаардлагаас хамааран GFSM 2014 стандартын бүтэцтэй уялдсан байх бөгөөд энэ нь олон улсын хэмжээнд төсвийн мэдээллийн харьцуулалт болон эдийн засгийн дүн шинжилгээ хийх суурь нөхцөлийг бүрдүүлдэг. GFSM 2014 дэлхийн хэмжээнд төсвийн ангиллын “нийтлэг хэл” буюу олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн жишиг стандартын үүргийг гүйцэтгэж байна.

Судалгаанд Киргиз, Армени, Гүрж, Молдова зэрэг орнуудын төсвийн ангиллыг авч үзэхэд дараах онцлогууд ажиглагдлаа:

- **Үндэсний онцлог:** Зарим улсад тусгай татвар, хөрөнгө оруулалтын гэх мэт ангилал нэмэлтээр орсон байх бөгөөд энэ нь тухайн улсын хууль эрх зүйн болон эдийн засгийн онцлогоос хамаарна.
- **Кодчилалын ялгаа:** Улс орнууд өөрийн үндэсний кодчиллын системийг ашигладаг боловч олон улсын байгууллагад тайлагнахдаа мэдээллээ GFSM-ийн бүтэцтэй нийцүүлэн гаргадаг. Үүний улмаас кодчлолын хувьд зөрүү гардаг ч ангиллын агуулга, зарчим нь ижил байна.
- **Мэдээллийн нарийвчлалын түвшин:** Зарим улс зөвхөн GFSM-ийн үндсэн бүлэг (Revenue, Expense, Net acquisition of nonfinancial assets, Financial transactions)-ийн түвшинд мэдээллээ гаргадаг бол зарим улс дэд бүлэг болон нарийвчилсан ангиллын түвшинд тайлагнадаг. Энэ нь институцын чадавх, статистик мэдээлэл боловсруулах нөөцөөс хамаардаг байна.

  Ихэвчлэн хөгжиж буй болон институцын чадавх сул орнууд зөвхөн GFSM-ийн үндсэн бүлэг (Revenue, Expense, Net acquisition of nonfinancial assets, Financial transactions гэх мэт)-ээр мэдээллээ гаргадаг. Энэ нь макро түвшний харьцуулалт хийхэд хангалттай боловч орлогын төрөл, зарлагыг нарийвчлан шинжлэх боломжийг хязгаарладаг. Харин институцын чадавх сайтай, бүртгэл мэдээллийн тогтолцоо хөгжсөн орнууд тайлангаа илүү нарийвчилсан ангиллаар гаргадаг. Тухайлбал, татварын орлогыг ажиллах хүчний татвар, хэрэглээний татвар, хөрөнгийн татвар гэх мэт төрлөөр нь ангилж задлан харуулдаг. Зарлагыг цалингийн зардал, бараа үйлчилгээний хэрэглээ, нийгмийн тэтгэмж, хүүгийн төлбөр гэх мэтээр нарийвчлан ангилдаг.

  Түүнчлэн зарим улс COFOG (Functions of Government Classification) ангиллын дагуу эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах гэх мэт салбарын чиглэлээр ангилж зэрэгцүүлэн тайлагнадаг.

  Иймээс мэдээллийн нарийвчлалын түвшин улс орнуудын хууль тогтоомж болон статистик, бүртгэл мэдээллийн хөгжлийн түвшингээс хамаарч харилцан адилгүй байдаг.

Ном зүй

OECD. (2025). *Revenue Statistics in Asia and the Pacific 2025: Kyrgyzstan © OECD 2025.* Хандах: https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2025/06/revenue-statistics-in-asia-and-the-pacific-2025-country-notes_0a069779/kyrgyzstan_fa9b181a/ca50a638-en.pdf#:~:text=,GDP%20ratio%20in

tradingeconomics. (2025). *Kyrgyzstan - Social Contributions (% Of Revenue).* Хандах: https://tradingeconomics.com/kyrgystan/social-contributions-percent-of-revenue-wb-data.html#:~:text=Kyrgyzstan%20,collection%20of%20development%20indicators%2C

The Government of the Republic of Armenia. (2024). *Ministry of Finance, Republic of Armenia.* Хандах: https://minfin.am/website/images/files/43d7ce77.pdf#:~:text=Share%20in%20GDP%2C%20,financial%20assets

IMF. (2025). *Kyrgyz Republic: 2025 Article IV Consultation-Press Release; and Staff Report.* Хандах: https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2025/06/04/Kyrgyz-Republic-2025-Article-IV-Consultation-Press-Release-and-Staff-Report-567394

IMF. (2024). *Republic of Armenia: Fourth Review Under the Stand-By Arrangement and Request for Modifications of Performance Criterion and Monetary Policy Consultation Clause-Press Release; Staff Report; and Statement by the Executive Director.* Хандах: https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2024/12/17/Republic-of-Armenia-Fourth-Review-Under-the-Stand-By-Arrangement-and-Request-for-559673

IMF. (2025). *Georgia: 2025 Article IV Consultation-Press Release; and Staff Report.* Хандах: https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2025/07/25/Georgia-2025-Article-IV-Consultation-Press-Release-and-Staff-Report-569007

IMF. (2024). *Republic of Moldova: Sixth Reviews Under the Extended Credit Facility and Extended Fund Facility Arrangements, Request for modifications of performance criteria, and Second review Under the Resilience and Sustainability Facility Arrangement-Press Release;.* Хандах: https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2024/12/19/Republic-of-Moldova-Sixth-Reviews-Under-the-Extended-Credit-Facility-and-Extended-Fund-559769

IMF. (2025). *Kyrgyz Republic: 2025 Article IV Consultation-Press Release; and Staff Report.* Хандах: https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2025/06/04/Kyrgyz-Republic-2025-Article-IV-Consultation-Press-Release-and-Staff-Report-567394

IMF. (2014). *Government finance statistics manual 2014.* Хандах: https://www.imf.org/external/pubs/ft/gfs/manual/2014/gfsfinal.pdf

UN. (2009). *System of National Accounts 2008.* Хандах: https://unstats.un.org/unsd/nationalaccount/docs/sna2008.pdf